



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/355

Булган сум

**Орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага
сургалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.5.24, 66 дугаар зүйлийн 66.1.1, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3.3, 11.4.2 дахь заалт, 11.8 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2026 оны А/50 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2026 онд хэрэгжүүлэх гэрээний 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймагт орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний хээрийн дадлага, сургалт зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага, сургалтад шаардагдах 42,648,000 (дөчин хоёр сая зургаан дөчин найман мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын батлагдсан төсвөөс, санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж, бэлтгэл ажлыг сайтар хангаж орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага сургалтыг Орхон сумын нутаг дэвсгэрт 2026 оны 05 дугаар сарын 25-наас 2026 оны 05 дугаар сарын 30-ны хугацаанд Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Рашаант, Хишиг-Өндөр, Орхон сумдын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнийг оролцуулан сахилга, баттай болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагууд, Орхон сумын Засаг дарга (С.Ганбаатар), Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штаб (дэд хурандаа Т.Нямхүү)-т тус тус даалгасугай.

4. "Хээрийн дадлага" сургуульд оролцох бие бүрэлдэхүүний хувийн бэлтгэл, техникийн бэлтгэлийг сайтар хангуулж, тогтоосон хугацаанд заагдсан районд бэлэн байлгахыг Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Орхон, Рашаант, Хишиг-Өндөр сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР




Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 13-ны/ний өдрийн
А/355 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)
- Гишүүдэд:
- Т.Нямхүү (Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
 - Г.Мөнхбат (Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч, хурандаа)
 - Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)
 - Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, хурандаа)
 - Д.Төгсбаяр (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа)
 - Д.Буян-Өлзий (Тагнуулын газрын дарга, дэд хурандаа)
 - С.Ганбаатар (Орхон сумын Засаг дарга)
 - Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
 - Г.Отгонбаяр ("Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" Төрийн өмчит хувьцаат компанийн Булган салбарын захирал)
 - О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
 - Э.Эрболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
 - С.Батнасан (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)
 - Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нар
- Нарийн бичгийн дарга: Б.Намнансүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, сургалтын офицер, дэд хурандаа)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
 05 дугаар сарын 13 -ныгний өдрийн
 Х/355 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ХЭЭРИЙН ДАДЛАГА СУРГАЛТАД
 ШААРДАГДАХ САНХҮҮГИЙН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Бүгд	Тайлбар
1	2	3	4	5		7
1	Хоол хүнс	Хүн	38,000	130*6	28,800,000	130 хүн*6 хоног Хүнсний материал 28,800,000
2	Анонс	ш	180,000	2	360,000	Сургалт
3	Сум	ш	2,400	1,000	2,400,000	АК -7,62мм
4	Старлик	ш	3,300,000	1	3,300,000	сургалтад
5	Буудлагын бай (наадаг бай)	ш	20,000	11	220,000	Буудлага
6	Булган аймгийн газрын зураг	ш	150,000	2	300,000	Маштаб 1см 400.000
7	Дэвтэр	Хүн	8,000	120	960,000	Сургалтад зориулж
8	Бал	Хүн	3,000	120	360,000	Сургалтад зориулж
9	Кофе, цай	ш	25,000	4	100,000	Сургалтад зориулж
10	Нэг удаагийн аяга	ш	10,000	10	100,000	Сургалтад зориулж
11	Буудлагын бай (модон бай)	ш	30,000	10	300,000	Буудлага
12	Түлшний мод	М³	700,000	2	1,400,000	Сургалтын гал тогоонд хэрэглэх 4м
13	Шаардагдах шатахуун /бензин/	Литр	2,720	800	2,176,000	Сургалтын бэлтгэл ажилд
14	Түлш	Литр	4,680	400	1,872,000	Сургалтын бэлтгэл ажилд
Бүгд					42,648,000	